

1. Дуулаачийн хөгжмийн төрөлд аль нь хамаарах вэ?
 а. Дуурь б. Бүжгэн жүжиг с. Симфони
2. Дуулаачийн хөгжмийн төрлийн хамгийн том хэлбэр аль нь вэ?
 а. Баллада б. Оратори с. Дуурь
3. Дуулаачийн хөгжмийн төрлийн хамгийн энгийн, жижиг хэлбэр юу вэ?
 а. Вокализ б. Дуу с. Романс
4. Хүүрнэл дуу аль нь вэ?
 а. Баллада б. Кантат с. Романс
5. Магтан дуулах агуулгатай найрал дууны төрөл аль нь вэ?
 а. Кантат б. Оратори с. Реквием
6. Аль нь дуулаачийн хөгжмийн төрөлд хамаарахгүй вэ? Сонгоод ялган тэмдэглэнэ үү?
 Үггүй дуу, хүүрнэл дуу, дуурь, эмгэнэлийн дуулал, ялгуусан дуулал, сюит, магтуу
7. Дуучны ур чадвар, дуулах арга барилыг хөгжүүлэхэд зориулагдсан дасгал буюу үггүй дуу хэмээн нэрлэгддэг төрөл аль нь вэ?
 а. Вокализ б. Романс с. Кантат
8. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу.
 1. Романс а. Магтуу А. 1b 2c 3a
 2. Баллада б. Хүүрнэл дуу В. 1a 2b 3c
 3. Кантат с. Дууль С. 1b 2a 3c
9. Ерөнхий нэрийг сонгоно уу?
 1. Реквием, Оратори, Кантат а. Гоцлол дуу А. 1a 2b
 2. Романс, Баллада, Вокализ б. Найрал дуу В. 1b 2a
10. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу.
 1. Дуурь а. Сэтгэл догдлом, баатарлаг үйл явдлын талаар уянгалаг өнгө аясаар өгүүлдэг
 2. Реквием б. Урлагийн бүх төрлүүдийг нэгтгэсэн нийлмэл төрөл
 3. Баллада с. Эмгэнэл харууслын шинж төрхтэй
 А. 1a 2b 3c
 В. 1c 2a 3b
 С. 1b 2c 3a
11. Зөв хариултыг олж дугуйлаарай.
 1. Вокализ а. Опера А. 1a 2b 3c
 2. Оратори б. Үггүй дуу В. 1b 2c 3a
 3. Дуурь с. Ялгуусан дуулал С. 1c 2a 3b